**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/039/НА-СТА-ТХН**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Долгорсүрэн<br>Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.mn<br><br>Аудитор: Ж.Бужинханд<br>Утас: 261740 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр<br>Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНД АШИГЛАХ ТОМ ЧАДЛЫН ХУРИМТЛУУРЫН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ М.НАРАНБАТ ТАНАА

2025.03.17 № 07/1084
танай ____________-ны №____________-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн ЭХЧТ-А/180/18/2024 дугаар техникийн комиссын дүгнэлтээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 80МВт/200МВтц хүчин чадалтай батарей хуримтлуурын станцыг ашиглалтад оруулж, Улсын комисс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Төслийн 80МВт/200МВтц хүчин чадалтай батарей хуримтлуурын станцыг барьж ашиглалтанд оруулах, эхний 2 жилийн ашиглалт, засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх гэрээт ажил 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох бөгөөд гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төслийн удирдах хорооны 16 дугаар зөвлөмжийн дагуу төслийн хэрэгжих хугацааг сунгуулах хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0319 SNAG-3 Docx

1525070985

**Бусад асуудлын хэсэг**

Төслийн нэгж нь 2024 оны үйл ажиллагааны 2 зорилтын хүрээнд нийт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 23, эрчимжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээ бөгөөд нийт хэрэгжилт 94.8 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсөв захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсөв захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0319 SNAG-3 Docx

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **144,016,432,610.42** | **290,082,101,776.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **355,120,102.48** | **240,829,915.47** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **355,120,102.48** | **240,829,915.47** |
| **3121** | **Төгрөг** | **18,033,901.62** | **28,442,274.99** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,033,901.62 | 28,442,274.99 |
| **3122** | **Гадаад валют** | **337,086,200.86** | **212,387,640.48** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 337,086,200.86 | 212,387,640.48 |
| **33** | **АВЛАГА** | **11,587,392.34** | **11,860,534.45** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 111,995.83 | 111,995.82 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага | 68,000.14 | 341,142.25 |
| **335** | **Бусад авлага** | **11,407,396.38** | **11,407,396.38** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 11,407,396.38 | 11,407,396.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **484,000.00** | **0.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **484,000.00** | **0.00** |
| 35470 | Бусад хангамжийн материал | 484,000.00 | 0.00 |
| **36** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **143,649,241,115.60** | **289,829,411,326.74** |
| 3680 | Бусад эргэлтийн хөрөнгө | 143,649,241,115.60 | 289,829,411,326.74 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **58,894,207.52** | **44,093,673.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **58,894,207.52** | **44,093,673.39** |
| **392** | **Биет хөрөнгө** | **56,584,207.52** | **42,443,673.39** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 58,939,760.00 | 58,939,760.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,684,251.85) | (34,557,952.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,054,533.00 | 34,538,533.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,725,833.63) | (16,476,666.92) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **2,310,000.00** | **1,650,000.00** |
| 39301 | Программ хангамж | 3,960,000.00 | 3,960,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,650,000.00) | (2,310,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **144,075,326,817.94** | **290,126,195,450.05** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **48,918,981.20** | **61,966,851.34** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **48,918,981.20** | **61,966,851.34** |
| **413** | **Өглөг** | **48,918,981.20** | **61,966,851.34** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,471,155.20 | 3,140,325.34 |
| **4136** | **Бусад өглөг** | **47,447,826.00** | **58,826,526.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 47,447,826.00 | 47,447,826.00 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 0.00 | 11,378,700.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **144,026,407,836.74** | **290,064,228,598.71** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **144,026,407,836.74** | **290,064,228,598.71** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 27,862,772,449.21 | 144,026,407,836.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 116,163,635,387.53 | 146,037,820,761.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **144,075,326,817.94** | **290,126,195,450.05** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **119,125,950,500.95** | **159,439,286,317.42** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **119,125,950,500.95** | **159,439,286,317.42** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **89,308,200,578.29** | **159,439,286,317.42** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **89,308,200,578.29** | **159,439,286,317.42** |
| 1200043 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 89,308,200,578.29 | 159,439,286,317.42 |
| **122** | **Тусламжийн орлого** | **29,817,749,922.66** | **0.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 29,817,749,922.66 | 0.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 0.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,964,584,207.65** | **13,400,503,361.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,964,584,207.65** | **13,400,503,361.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,964,584,207.65** | **13,400,503,361.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **321,803,474.87** | **326,197,300.00** |
| 210101 | Үндсэн цалин | 321,803,474.87 | 326,197,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,519,114.00** | **40,498,816.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,519,114.00 | 40,498,816.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **65,028,000.00** | **78,180,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 65,028,000.00 | 78,180,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,223,190.94** | **5,014,005.47** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,672,818.00 | 1,880,626.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,660,000.00 | 2,267,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 805,372.94 | 866,379.47 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 85,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,512,786,393.71** | **12,933,447,768.32** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 786,032,691.28 | 2,061,630,264.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 29,260,000.00 | 30,000,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 171,095.00 | 169,813.50 |
| 210813 | Бусад зардал | 1,697,322,607.43 | 10,841,647,690.82 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **15,224,034.13** | **17,165,471.13** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,880,937.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,224,034.13 | 15,284,534.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **116,161,366,293.30** | **146,038,782,956.01** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **2,801,722.31** | **150,162.45** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 2,801,722.31 | 150,162.45 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **532,628.07** | **1,112,356.49** |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 532,628.07 | 1,112,356.49 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **2,269,094.23** | **(962,194.04)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **116,163,635,387.53** | **146,037,820,761.97** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **412,342,816.75** | **366,858,151.46** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **412,342,816.75** | **366,858,151.46** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **412,342,816.75** | **366,858,151.46** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **412,342,816.75** | **366,858,151.46** |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 412,342,816.75 | 366,858,151.46 |
| 120009 | Бусад орлого | - | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **171,095.00** | **169,813.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **171,095.00** | **169,813.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **171,095.00** | **169,813.50** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **171,095.00** | **169,813.50** |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 171,095.00 | 169,813.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **412,171,721.75** | **366,688,337.96** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | **2,801,722.31** | **150,162.45** |
| 145004 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 2,801,722.31 | 150,162.45 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **484,779,624.76** | **480,016,330.93** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 484,779,624.76 | 480,016,330.93 |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | **532,628.07** | **1,112,356.49** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 532,628.07 | 1,112,356.49 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(482,510,530.53)** | **(480,978,524.97)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (70,338,808.78) | (114,290,187.01) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 425,458,911.26 | 355,120,102.48 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 355,120,102.48 | 240,829,915.47 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **27,862,772,449.21** | **27,862,772,449.21** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **27,862,772,449.21** | **27,862,772,449.21** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | 116,163,635,387.53 | 116,163,635,387.53 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **144,026,407,836.74** | **144,026,407,836.74** |
| **D02** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **144,026,407,836.74** | **144,026,407,836.74** |
| D03 | Тайлант үеийн үр дүн | | 146,037,820,761.97 | 146,037,820,761.97 |
| D04 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **290,064,228,598.71** | **290,064,228,598.71** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **179,967,516,872.00** | **159,553,576,504.44** | **20,413,940,367.56** | **88.7** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **179,967,516,872.00** | **159,553,576,504.44** | **20,413,940,367.56** | **88.7** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 179,967,516,872.00 | 159,553,576,504.44 | | 88.7 |
| **3** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **179,967,516,872.00** | **159,439,286,317.42** | **20,528,230,554.58** | **88.6** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **179,967,516,872.00** | **159,439,286,317.42** | **20,528,230,554.58** | **88.6** |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 179,967,516,872.00 | 159,439,286,317.42 | | 88.6 |
| | Төсвийн тохируулгын дүн | | | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 355,120,102.48 | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 240,829,915.47 | | |
| **6** | **Төсвийн бусад мэдээлэл** | | | | |
| 61 | Байгууллагын тоо | 1 | 1 | | 100.0 |
| 62 | Ажиллагсадын тоо | 8 | 8 | | 100.0 |
| 62001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| 62002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1. Аудитаар нийт 511,618.7 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХХОАТ-ын авлагыг санхүү байдлын тайланд өр төлбөр хэсэг дээр тайлагнасан. | 1 | 341.1 | | | 1 | 341.1 | 1 | 341.1 | | | | |
| Элэгдлийн зардал зөрүүтэй тайлагнасан | 1 | 60.5 | | | 1 | 60.5 | 1 | 60.5 | | | | |
| Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг өртгийг дутуу тооцоолсон. | 1 | 511,217.1 | | | 1 | 511,217.1 | 1 | 511,217.1 | | | | |
| **Дүн** | **3** | 511,618.7 | | | **3** | **511,618.7** | **3** | **511,618.7** | | | | |

3.2. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснийг хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хугацаа хоцроож ирүүлсэн | 1 | - | | | 1 | - | 1 | |
| | **Нийт дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | **1** | |

---
[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/